

## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

### НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс одоог хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар 15,172,366.4 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компани болно.

### ХОЁР. 2018 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

#### УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

##### Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа 2018 онд (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж ажилласан.

Компанийн захиргаа 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2017 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн тухай PWC аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох, компанийн 2018 оны төлөвлөгөө, орлого, зардлын төсөв зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн захиргаа Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн зохицуулах байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн хийж, хүчин төгөлдөр саналын эрхийн 85.6 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг хуралд оролцогчдын 99.99-100 хувийн саналын эрхээр батлуулж шийдвэрлүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д

хуульд заасан хугацаанд хүргүүлж, хууль тогтоомж, төрийн зохицуулах байгууллагаас гаргасан журам, хугацааны заалтыг хэрэгжүүлж ажилласан.

2018 онд хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүн сонгогдсон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд сонгогдсон гишүүдийн тухай мэдээллийг Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2018.02.05-ны №01 тогтоол)-ийн дагуу компанийн 2017 оны цэвэр ашгаас 1,189,983 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,518.2 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүний орлогын албан татварт 12,851.8 мянган төгрөг суутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 115,666.3 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 634 хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр байршуулан олгож, хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнаж, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоол, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журам, Санхүүгийн зохицуулах хорооноос цахим хуудсаар өгсөн зөвлөмжүүд, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2018 оны 01/64 тоот хамтран ажиллах бичиг, мэдээллийн хуанлийн дагуу санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, зохих байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх ажлыг биелүүлж ажилласан.

Компанийн гүйцэтгэх удирдлагын ажилтнууд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс зохион байгуулсан компанийн засаглалтай холбогдолтой хурал, семинар, сургалтад оролцож, судалгаа, мэдээлэл авч компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажилласан.

Компанийн веб хуудасны мэдээ мэдээллийг тухай бүрт нь шинэчилж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

2018 онд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсч бий болоогүй болно.

Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зорилгоор Компанийн хуулийн 45 дугаар зүйлийн 45.5-д зааснаар эзэмшигчийн эрх үүсээгүй 18,413 ширхэг хувьцаа эзэмшдэг 306 хувьцаа эзэмшигч болон тэдэнд хуваарилсан 12,084,000 мянган төгрөгийн ногдол ашгийн судалгаа хийж, тэдгээр хувьцаа эзэмшигчдийн хувьцаа

эзэмших эрх үүссэн эсэх болон хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг баталгаажуулах, регистержүүлэх талаар Бумбат-Алтай ҮЦК-тай нууц хадгалах гэрээ байгуулж, зөвлөх үйлчилгээ авсан.

Зөвлөх үйлчилгээний дагуу дээрх 306 хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр баталгаажуулсан баримт бичгийг Монголыг хөрөнгийн биржийн архиваар лавлагаа хийлгэх, харъяалагдах Үнэт цаасны компаниудын эх баримттай тулгах, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансны бичилтийг баталгаажуулах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлтэй тулгаж регистержүүлэх ажлыг 2019 онд хийх болсон.

Компани 2018 онд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанийн болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Тахько (ХК) компани 2018 онд компанийн засаглалын зарчим, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласнаар Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 12 дугаар зүйлийн 12.1-ийн 12.1.1-12.1.4, 12.2-ын 12.2.1-12.2.4 дэх хэсэгт заасан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны шалгуур (тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй аудитын байгууллагаар баталгаажуулах, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг, компанийн зах зээлийн үнэлгээ, гаргасан үнэт цаасны нийтэд санал болгосон хувь, компани нь засаглалын болон мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг)-ын дагуу хоёрдугаар ангилалын нээлттэй компанийн шаардлагыг хангаж байна.

Компанийн засаглалын кодекс, зарчмыг хэвшүүлэх зорилгоор 2019-2022 онд сайн засаглалыг бүрэн хэрэгжүүлэх 4 зорилт, 2 үе шаттай хөтөлбөр боловсруулсан.

### **Компанийн бүтэц, зохион байгуулалт**

Компани 2018 онд Гүйцэтгэх удирдлага, Захиргааны болон Техник үйлчилгээний алба, Анкор төв гэсэн бүтэцтэй ажилласан.

Компанийн 2018 онд мөрдөх орон тоо, албан тушаалтны үндсэн цалингийн хэмжээг Гүйцэтгэх захирлын 2018.01.02-ны өдрийн 01 дүгээр тушаалаар баталж, байнгын ажлын байрны 29 орон тоо (ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга ороод)-той ажиллахаар төлөвлөж, 26 орон тоо (Эдийн засагч, төсөл хөтөлбөр, тооцоо судалгаа хариуцсан мэргэжилтэн, Анкорын менежерийн орон тоонд хүн ажиллуулаагүй)-оор ажилласан.

Ажилтнуудтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон ажлын байрны үндсэн цалингийн хэмжээг мөрдөж, тэдний ажлын үр дүнг харгалзан Гүйцэтгэх захирлын 2016 оны 16 тоот тушаалаар баталсан журмын дагуу улиралд нэг удаа үндсэн цалингийн 40 хүртэл хувийн урамшуулал олгож байна. 2018 онд ажилтнууд, удирдлага, ТУЗ-ын гишүүдийн цалин урамшуулалд нийтдээ 974,181.664 төгрөг олгож, цалингийн зардал компанийн нийт зардлын 37.5 хувь болсон.

Компанийн 2017 оны санхүүгийн тайланг "А" форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Прайсуотерхаускуперс аудит ХХК-аар олон улсын түвшингийн аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн удирдах зөвлөл болон 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

2018 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх компаниар Прайсуотерхаускуперс аудит ХХК-ийг дахин сонгох шийдвэр (Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018.06.25-ны 11 дүгээр тогтоол) гаргуулж, Аудитын гэрээ (2018.09.24-ний өдөр) байгуулж, компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд олон улсын түвшингийн аудитын баталгаажуулалт хийлгэж, дүгнэлт тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн.

Компани, Компанийн дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн материал, сэлбэг хэрэгслэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн их болон урсгал засвар хийх, үйлчилгээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр сонголт хийсэн ажил гүйцэтгэгчидтэй 45 гэрээ байгуулж, тэдгээр гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, ажлын үр дүнг зохих журмын дагуу актаар хүлээн авч, төлбөр тооцоог хийж дуусгасан.

Компанийн өмч хөрөнгө, ажилтныг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал компанитай үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээнүүдийг шинээр байгуулж, гэрээнүүдийн дагуу 2018 онд даатгалын хураамжинд 11,701.5 мянган төгрөг төлсөн байна.

Даатгалын хугацаанд Теди төв (2018 оны 4 дүгээр сарын 21)-ийн 3 дугаар давхрын цонх хагалж хулгай хийсэн этгээд вакуум цонхыг дахин ашиглах боломжгүй болгосон тохиолдлоос учирсан 66.0 мянган төгрөгийн, компанийн тээврийн хэрэгсэл (2288УНЗ дугаартай Тоёота ланд крузер 200, 2449 УБС дугаартай Тоёота ланд крузер 105)-үүдэд гарсан 4 удаагийн даатгалын тохиолдлоос учирсан 2,750.0 мянган төгрөгийн хохирлыг даатгалын 100 хувийн нөхөн төлбөрөөр засвар үйлчилгээ хийлгэж хэвийн байдалд оруулсан.

Компанийн мэдээллийн системийн хэвийн, аюулгүй ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх зорилгоор мэдээллийн технологийн үйл ажиллагаа явуулдаг туршлагатай Супреим Сольюшн ХХК-тай хамтран ажиллах, ажил гүйцэтгэх гэрээнүүд байгуулж, интернет, сүлжээний чанар, компьютерын болон камерын төхөөрөмжийн байдалд дүгнэлт гаргуулж энэ үндсэн дээр интернетийн утасгүй сүлжээний сайжруулалт хийлгэж, утасгүй сүлжээний Wireless access point төхөөрөмж, Unifi controller сервер суурилуулж, мэдээллийн системийн саатал, гэмтэл, тохиргооны өдөр тутмын үйлчилгээ хийлгэдэг болсон.

Үүнтэй холбогдуулан компанийн мэдээллийн системийн аюулгүй байдлын журам, мэдээллийн системийг ашиглах зааврыг Супреим Сольюшн ХХК-тай хамтран боловсруулж, уг журам зааврыг Гүйцэтгэх захирлын (2018.11.30-ны өдрийн 75 дугаар) тушаалаар баталж, мэргэжлийн инженер ажилтнуудаар нийт ажилтнуудад журам, зааврыг хэрэгжүүлэх сургалт явуулан мөрдөж байна.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиар хүлээсэн үүрэг, компанийн цахилгаан эрчим хүчний ашиглалт зарцуулалтад дүгнэлт хийх зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооны зөвшөөрөлтэй Мон-энержи консалтинг ХХК-тай гэрээ (2018.03.01-нд Ажил гүйцэтгэх) байгуулж, компани (МА-1, МА-2, МА-3, U-1 барилга)-ийн цахилгаан эрчим хүчний ашиглалт, зарцуулалтад аудит хийлгэж, тайлан дүгнэлт гаргуулж, Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлж тайлагнасан.

Эрчим хүчний аудитыг анх удаа хийлгэж, аудитын дүгнэлтийн дагуу эрчим хүч хэмнэх талаар зарим ажил хийгдсэн нь онцлох ажил болсон.

Эрчим хүчний аудитын дүгнэлтийн дагуу:

- МА-II барилгын 2, 3, 4 дүгээр давхарт агааржуулалтын систем шинээр угсарч суурилуулах их засварын ажлыг Салхивчвинт технологи ХХК-тай гэрээ байгуулан барилгын давхар тус бүрт цэвэр агаар оруулах, бохир агаар соруулж гаргах Швед улсын Остберг фирмийн 9 ширхэг АОС-1, АОС 2, АСС-1 механик сэнс, винтлятор, өвлийн улиралд гаднах агаарыг халаах 18 киловатын 6 ширхэг агаар халаагч суурилуулж, давхар бүрт 6 салаа нийт 930 метр агааржуулалтын хэвтээ хоолойн угсралтын ажил хийлгэсэн. Энэ ажлын үр дүнд доторх агаарын чанар сайжирч, СО-2-ын хэмжээ буурсан. Агаар сэлгэлтийн систем нь дунджаар 7,500 м<sup>3</sup> агаарыг сэлгэх бөгөөд нэг цагт заалны агаарыг 2-3 удаа сэлгэснээр амьсгалах таагүй орчин бүрдүүлдэг устөрөгчийн дутуу ислийг зайлуулж агаарын чанарыг сайжруулж байна.
- МА-II барилгын 2, 3 дугаар давхрын гэрэлтүүлэг солих урсгал засварыг Энрэн ХХК-тай гэрээ байгуулан хийлгүүлж, тус бүр нь 54 ватт цахилгаан зарцуулдаг 400 ширхэг люминесент өдрийн гэрлийг тус бүр нь 36 ватт зарцуулдаг 300 ширхэг ЛЕД гэрлээр сольсон. Энэ ажлын үр дүнд гэрэлтүүлэг сайжирч уг гэрлийг сольсноос хойших 8 сарын хугацаанд 25,920 кВт/цаг эрчим хүч буюу гэрэлтүүлэгт хэрэглэгдэх цахилгаан эрчим хүчийг 50 хувь хэмнэсэн.
- МА-III барилгын 1 ба 2 дугаар контурын дулаалаггүй халаалтын шугамын дулаалга хийх ажлыг Сизов ХХК-тай гэрээ байгуулан хийлгэсэн. Энэ ажлын үр дүнд 2017 онд дулаан авсан эхний 3 сар (10, 11, 12 дугаар сар)-д 3,444 ГКал дулаан хэрэглэж байсан бол 2018 оны дулаан авсан эхний 3 сар (10, 11, 12 дугаар сар)-д 3,033 ГКал дулаан хэрэглэж, 411 ГКал дулаан буюу 11,381.0 мянган төгрөгийн хэмнэлт гарч, дулааны зардал 11 хувиар буурсан.

Оёдлын үйлдвэр, компаниас өндөр насны тэтгэвэрт гарсан Хөдөлмөрийн баатар, гавьяат ажилтан болон өндөр настай 21 ахмад настныг цагаан сарын баяраар, компанид харьяалагддаг 300 ахмад настныг Ахмадын баяраар тус тус хүлээн авч 21,010.0 мянган төгрөгийн зардлаар хүндэтгэн Ахмад настны хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн.

Оёдлын үйлдвэр, Тахько (ХК) компанид ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан Хөдөлмөрийн баатар Л.Дашням, Б.Дугуйцагаан, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан А.Даваа, нас барсан болон гачигдал тохиолдсон ахмад настан А.Жүгдэржав, Ц.Дэжид, Н.Оюунсүрэн, Н.Өлзийтогтох, Б.Магсар нарт 2,433.3 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгож, Хөдөлмөрийн баатар П.Дамдингийн эмчилгээ,

оршуулгын ажилд 6,111.1 мянган төгрөгийн тусламж үзүүлж, Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн хэлтэст 550.0 мянган төгрөгийн, "Чанартай амьдрал" ТББ-д 20,000.0 мянган төгрөгийн хандив олгосон.

Шинэ жилийн баярыг тохиолдуулан хамтран ажилладаг байгууллага, харилцагчийн 150 ажилтанд мэндчилгээ дэвшүүлж хүндэтгэсэн.

### **Хүний нөөц, нийгмийн хариуцлагын асуудал**

Компани тайлангийн хугацаанд 26 хүний бүрэлдэхүүн (түр ажилласан, халагдсан хүмүүсийг оролцуулахгүйгээр)-тэй ажиллаж, тэдгээр ажилтнууд хууль тогтоомжид зааснаар давхардсан тоогоор ажлын 6,408 өдөр ажиллахаас 5,743 өдөр ажиллаж, 509 өдрийн ээлжийн амралтыг биеэр эдэлж, гачигдал тохиолдсон 10 ажилтанд давхардсан тоогоор 169 өдрийн захиргааны чөлөө олгож, 4 ажилтан хөдөлмөрийн чадвар түр алдаж 20 өдрийн ажлаас чөлөөлөгдсөн байна.

Компанийн ажилтнуудтай өмнө нь хугацаагүй байгуулсан Хөдөлмөрийн гэрээний талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлага, гэрээг сунгах, цуцлах нөхцөлд өөрчлөлт оруулж, ажилтнуудтай тохиролцсоны үндсэн дээр гэрээг жилийн хугацаатай байгуулж, жилийн эцэст дүгнэж сунгаж байхаар тохиролцож, шинэчилсэн Хөдөлмөрийн гэрээг 23 ажилтантай байгуулан мөрдөж ажилласан.

Мөн эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээх албан тушаалтнуудын жагсаалтыг Гүйцэтгэх захирлын 2018.01.17-ны өдрийн 03 тоот тушаалаар баталж, тэдгээр албан тушаалтантай Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын ба нууц хадгалах гэрээнүүдийг Хөдөлмөрийн гэрээний хугацаагаар байгуулан мөрдөж ажилласан.

Зарим ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, Менежер Э.Чулуунтогтохын ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулж Менежер Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын туслахаар, нягтлан бодогч Б.Сольрагчааг Ерөнхий нягтлан бодогчоор тус тус томилж, иргэн Б.Норжмааг нягтлан бодогчоор, иргэн Г.Сүхбаатарыг Гүйцэтгэх захирлын туслахаар (туршилтын хугацаагаар ажиллуулж) тус тус томилсон. Ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнэчимэгийг захиргааны санаачлагаар, үйлчлэгч Н.Эрдэнэчимэгийг Анкор төвийг түрээсэлснээс ажлын байргүй болсон тул хөдөлмөрийн гэрээг цуцалж, ажлаас халж, ажлыг хүлээн авч компанитай хийх тооцоог дуусгасан.

Компанийн ажилтнуудад Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон үндсэн цалин олгож, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэг, хариуцсан ажлын биелэлт, үр дүнг үндэслэн улиралд нэг удаа үндсэн цалингийн 40 хүртэл хувийн цалингийн урамшуулал олгож байна.

Нийт ажилтнуудын ажлын тайланг улирал тутам бичүүлж, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтын чиг үүргийн дагуу дүгнэж, 2018 онд ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн ажил үүрэг, хөдөлмөрийн гэрээ, дотоод журмын зарим заалтыг бүрэн биелүүлээгүй гэж үзсэн 4 ажилтны цалингийн урамшууллыг 5-10 хувиар хасч ажлын хариуцлагыг дээшлүүлэх хөшүүрэг болгож байна.

Менежер Э.Чулуунтогтохыг Удирдлагын академид бизнесийн удирдлагын бакалаврын 2 дахь жилд, Ерөнхий нягтлан бодогч Б.Сольрагчааг мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах, СЭЗДС-ийн санхүүгийн тайлагнал сэдэвт багц цагийн болон Монгол, Японы төвийн бизнесийн үндсэн сургалт, уг сургалтаар эзэмшсэн мэдлэгийг бататгах дадлага (Япон улсад явж компаниудын үйл ажиллагаа, стратеги, бодлого төлөвлөлт, өөрийн компанид авч хэрэгжүүлж болохуйц арга туршлагатай танилцах)-жуулах сургалтуудад, сантехник, цахилгааны ажилтан (8 хүн)-уудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд, цахилгаанчин (4 хүн)-дыг аюулгүй ажиллагааны эрх сунгах сургалтанд, цахилгаанчин Б.Отгонбатыг мэргэжлийн инженерийн багц цаг тооцох сургалтанд, Техник үйлчилгээний албаны дарга Ж.Ганхуягийг мэргэшсэн төсөвчний, Ж.Ганхуяг, М.Баянжаргал нарыг мэргэшсэн инженерийн тасралтгүй боловсролын сургалтанд тус тус суралцуулсан.

Гачигдал, хүсэлтийг харгалзан компанийн 10 ажилтан (Ц.Зоригт аав нь нас барсан, ээж, эхнэрээ асрах, Г.Сүхбаатарт ээжийгээ гадаад эмчлүүлэх болсон гачигдлаар тус бүр 65 өдрийн, Ц.Доржготов, Э.Чулуунтогтох, Б.Норжмаа, Н.Гомбосүрэн, Ж.Ганхуяг, Х.Баярмаа, Н.Эрдэнэчимэг нарт гэр бүл, хүүхдээ эмчлүүлэх, асрах, бэр гуйх, оршуулгын ажилд оролцох зэрэг шалтгаанаар 1-12 өдрийн)-д 169 өдрийн захиргааны чөлөө олгож амьдрал ахуйгаа зохицуулахад нь дэмжлэг үзүүлсэн.

Гачигдал тохиолдсон ажилтан (жолооч Ц.Зоригт 2,777.7, албаны дарга Ж.Ганхуяг, нягтлан бодогч Б.Норжмаа нарт тус бүр 333.3, шинээр хүүхэдтэй болсон Ц.Зоригт 500.0, мөн гачигдалтай байгаа ажилтны хүсэлт, амьдрал ахуйг нь дэмжих зорилгоор цахилгаанчин М.Болдод 2,222.2, Э.Чулуунтогтоход 5,555.5, Д.Баярхүүд 555.5, Х.Баярмаад 555.5)-дад 12,833.3 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

Ажилтнуудын ажлын цаг ашиглалт, захиргааны чөлөө олголт, Хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргийн биелэлтийг гаргаж, алба, ажилтнуудын ажлын тайланг улирал тутам бичүүлж, ажилтан бүрт дүгнэлт, зөвлөгөө өгч, ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэхэд хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

Ажилтнуудын ерөнхий мэдлэгийн түвшинг дээшлүүлэх болон цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор эрхэлсэн ажил, хууль тогтоомж, байгууллагын соёл, ажлын байрны болон мэдээллийн технологийн аюулгүй байдал, багаар ажиллах, хүчирхэг баг бүрдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн мэдвэл зохих асуудал, эрүүл мэнд, эрүүл хооллолт, мөнгөний бодлого имфляци, EQ чадвар, хүн амын орлогын албан татвар, замын хөдөлгөөний дүрэм журам, компанийн дотоод ажил, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт зэрэг асуудлаар сар тутамд 2 удаа сонсгол, мэдээлэл хийж байна.

Компанийн ажилтнуудын эрүүл мэнд, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор сагс, гар бөмбөгийн тоглолтыг 7 хоногт нэг удаа хийж, компанийн оны аварга баг шалгаруулах тэмцээн зохион явуулж, хамт олны өөрсдийн санаачлагаар зохион явуулж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагааг дэмжиж, цаашид уламжлал болгон хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нийт ажилтнуудыг Сөүл сонгдо эмнэлэгт нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх багц үзлэг, шинжилгээ оношлогоог компанийн зардал (5,200.0 мянган төгрөг)-аар хийлгүүлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгүүлж, зарим ажилтнууд эмчилгээ хийлгэсэн.

Нийт ажилтнуудыг хамарсан (Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Завхан аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудаар) 4 өдрийн алжаал тайлах аялал зохион байгуулсан.

Компанийн нийгмийн хариуцлагыг хангах хүрээнд Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтсийн гэр бүлийн уулзалт, Замын цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан Бага тойруу орчмын замын хөдөлгөөний зохицуулалтын талаарх уулзалт хурал, Татварын хэлтсээс зохион байгуулсан Тайлангийн хурал зэрэг арга хэмжээнүүдийг өөрийн Анкор төвд үнэ төлбөргүй зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Гурвалжингийн аж ахуйн хашааны доторх орчин, агуулахад 4 ширхэг, компанийн төв байр барилгуудын гаднах орчин болон Ж.Самбуугийн гудамжны Капитал банкнаас Хүнсний 1 дүгээр дэлгүүр, Баруун сэлбийн гудамжны Берлин төвөөс Улсын их дэлгүүр чиглэлийн гудамж, талбай, авто замыг хамарсан 3,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий өндөр хүчин чадлын 4 ширхэг камерийг өөрийн хөрөнгөөр худалдан авч суурилуулсан.

Эдгээрээс компанийн төв байрны гаднах камеруудыг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн системд холбож, цагдаагийн байгууллагаас компанийн нутаг дэвсгэрийн харалдаах гудамж талбай, авто замын хөдөлгөөнд хяналт тавих нөхцлийг бүрдүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажил үйлст хувь нэмэр оруулж, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн үр дүнтэй ажил болсон.

Дүүргийн цагдаагийн байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж бичиг хэвлүүлж түрээсээр үйл ажиллагаа явуулдаг Теди төв, Скайтелийн үйлчилгээний төвийн орох гарах хаалга, хүмүүс олноор үйлчлүүлдэг цэгүүдэд байршуулж, Теди төвийн гаднах зогсоолын талбай, орох гарах хаалганы орчимд гар дээрээс гар утас худалдах худалдан авахыг хориглосон анхааруулга, самбар хийлгэж байршуулах зэргээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Анкор төвийн орох хаалганд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу орц гарц бий болгож хийсэн.

## **ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**

**Компанийн орлого нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр**



Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бүх төрлийн хог хаягдал, нүүрснээс шингэн түлш болон цахилгаан гаргаж авах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Төслийн бэлтгэл ажлын хүрээнд Японы олон улсын агентлаг ЖАЙКА-ийн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээлд хамрагдах баримт бичиг боловсруулж, Худалдаа хөгжлийн банкинд оруулж, Олон улсын байгууллагаас бүсийн зах зээлийн нарийвчилсан судалгаа худалдаж авахад шаардлагатай мэдээллүүдийг бэлтгэж байна.

Төслийн бэлтгэл ажилд шаардлагатай эрчим хүч, түлш боловсруулах, химийн бодис оруулж ирэх зэрэг тусгай зөвшөөрөл авах судалгаа мэдээллүүдийг бэлтгэсэн.

Төслийн ажлын хүрээнд Улаанбаатар хотын айл өрхийн түлшний хэрэглээг бууруулах туршилтын зуух хийх 8,770.6 мянган төгрөгийн ажлыг иргэн Ж.Баясгалантай гэрээ байгуулан хийлгэж, уг зуухыг турших бэлтгэлийг хангасан.

Төслийн бэлтгэл ажлын чиглэлээр Япон улсад томилолтоор ажиллаж хамтран ажилладаг GGI trust компанийн удирдлагатай уулзаж, төслийн ажлын явцын талаар танилцуулга хийж, хөрөнгө оруулалтын шийдлүүдийн талаар ярилцаж санал солилцсон.

Хаягдал тосноос дизель түлш үйлдвэрлэх төслийн Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад шаардлагатай урьдчилсан судалгааны 5,060.3 мянган төгрөгийн ажлыг Эс Ай Си Эй ХХК-тай гэрээ байгуулж, хийлгэсэн.

Дархан-Уул аймагт үйлдвэр байгуулах газрын газар тэгшлэх газар шорооны ажил гүйцэтгэж, эзэмшил газрын 2018 оны 7,760.0 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн.

Мөн газрыг хашаажуулах ажлын хүрээнд БНХАУ-ын Фей Юу Төмөр тор ХХК-тай гэрээ байгуулж, төмөр торон хашаа худалдан авч бэлтгэсэн.

Төмөр торон ба бетонон хашаа, контейнер, бусад материалыг Улаанбаатараас Дархан хүртэл тээвэрлэх, 1,800 метр хашаа барих ажлыг Баб инвест ХХК-тай гэрээ байгуулан хийлгэж, ажлын гүйцэтгэлийг актаар хүлээн авч, 2 жилийн баталгаа гаргуулсан.

Хашаа, хашаан дотор байрлах контейнерыг харж хамгаалах ажлыг зэргэлдээ байрлах байгууллагын харуулын ажилтантай хөлсөөр ажиллах гэрээ байгуулан гүйцэтгүүлж, уг ажилтан өөрийн байгууллагын харуулын байранд ажилладаг тул харуулын байр шинээр барих шаардлагагүй болсон.

Мөн газрын хашаа барьсантай холбогдуулан иргэн Н.Эрдэнэбилэгтэй 2018.11.29-нд Хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, газар, хашаа, эд хөрөнгийг хамгаалж харуулах сахиулын үүрэг гүйцэтгүүлж байна. (Цалингийн зардал 559,000 мянган төгрөг)

Төслийг эхлүүлэх ажлын хүрээнд Япон улс, БНХАУ-ын Эрээн хотод 3 удаа 22,615.9, Дархан-Уул аймагт 12 удаа 9,276.9 мянган төгрөгийн зардлаар томилолтоор явж ажилласан. Бусад зардал (Баримт бичгийн орчуулгын)-д 110.0 мянган төгрөг төлсөн байна.

Компанийн үл хөдлөх хөрөнгийн ирээдүйн хөгжлийн архитекторын ажлын зургийг өмнөх онд байгуулсан гэрээний дагуу үргэлжлүүлэн хийж байгаатай холбогдуулан ажлын зураг хийхэд шаардлагатай барилга барих газрын өрөмдлөгийн цэгүүдийн газар доорх шугам сүлжээг тандан судлах 1,105.0 мянган төгрөгийн ажлыг “Эм Эйч И” ХХК-тай, хөрсний геологийн өрөмдлөг хийж судалгаа дүгнэлт гаргуулах 50,280.2 мянган төгрөгийн ажлыг Сойл трейд ХХК-тай, газар хөдлөлийн аюулын үнэлгээг нарийвчилан тодорхойлох 9,720.0 мянган төгрөгийн ажлыг Шинжлэх ухааны академийн Одон орон геофизикийн хүрээлэнтэй тус тус гэрээ байгуулан гүйцэтгүүлж судалгаа дүгнэлт тайлан гаргуулж ажлын зураг хийж байгаа Архера ХХК-д хүлээлгэн өгсөн.

МА-I, МА-II, МА-III, U-I барилга (оффис, үйлчилгээ, дэлгүүр, засварын цехийн зориулалттай)-уудын хана, хучилт, даацын бүтээц болон барилгуудад оношлогоо, лабораторын шинжилгээ хийж, насжилт тогтоосон дүгнэлт гаргах 22,500.0 мянган төгрөгийн ажлыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Оношлогоо, зураг төсөл, судалгааны Реконстракшн төвтэй Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж хийлгэсэн.

Компани өөрөө үйл ажиллагаа явуулж байсан Анкор төвийг тоног төхөөрөмж, эд хогшлын хамт Мондактс ХХК-тай гэрээ байгуулан 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 онд сард 6,000.0, 2019 онд сард 7,000.0 мянган төгрөгийн төлбөрийн нөхцөлөөр түрээсэлж, компанийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн.

## **Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр**

### **Их болон урсгал засварын ажил**

Компанийн барилга байгууламжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор Гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан МА-II барилгын 2, 3, 4 дүгээр давхрын агааржуулалтын системийг шинээр суурилуулах ажлыг 166,014.3 мянган төгрөгийн, Гурвалжин дахь аж ахуйн хашаа барьж, агуулахын дээвэр, фасад засварлах ажлыг 93,340.9 мянган төгрөгийн, Автомашины гараашийн дээвэр, ар талын фасад, хажуу талд нэмэлт хана өрөх засварын ажлыг 24,809.0 төгрөгийн, Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах үйлдвэр байгуулах газарт барих төмөр торон хашааг БНХАУ-ын Эрээн хотоос худалдан авч, төмөр торон болон бетонон хашаа, контейнер тээвэрлэх, хашаа барих ажлыг 59,707.3 мянган төгрөгийн, нийтдээ 343,871.5 мянган төгрөгийн их засварын ажил хийж гүйцэтгэсэн.

Оффис, Анкор төвийн барилгын урсгал засвар, авто зогсоолд усны хаялга хийх, МА-II барилгын 2, 3 дугаар давхрын гэрэлтүүлгийг цахилгааны хэмнэлттэй гэрлээр солих, ХПТ-477 дэд өртөө, цахилгааны самбар шинэчлэх, ачаалал тэнцүүлэх, кабель утас солих, татах, дулааны тоолуур, узелийн цахилгаан насос түүний дагалдах хэсгийг солих, халаалтын систем угаах, шугам хоолой, радиатор солих, халаалтын системийн дулаалга хийх зэрэг 115,500.4 мянган төгрөг (барилгын 10,927.7, цахилгааны 79,792.2, сантехникийн 24,780.5)-ийн урсгал засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

### **Хэвийн үйл ажиллагааг хангах өдөр тутмын ажил**

Цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 340,995.4

мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хувиарлан төлүүлсэн. Үүнд: цахилгаан 306,341.6 цахилгааны тоолуурын зөрүү 9,025.8, тарифийн зөрүү 13,018.0, үйлчилгээний үнэ 12,609.9 мянган төгрөгийг хэрэглэгчдэд хуваарилж төлбөрийг хийлгэсэн.

Дулааны төлбөрт 55,971.3, үйлчилгээний төлбөрт 1,004.1 цэвэр бохир усны төлбөрт 32,530.1, усны үйлчилгээний төлбөрт 1,237.6, телефон ярианы төлбөрт 1,076 мянган төгрөгийг хэрэглэгчид хуваарилан төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласанаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй, бэлэн мөнгөний зарцуулалт, түүнд тавих хяналт хэвшсэн болно.

Компанийн үндсэн үйл ажиллагаа болох түрээсийн орлогыг бүрдүүлэх ажлыг гэрээний дагуу хийж, түрээслэгч компаниудтай тооцоо нийлж ажилласнаар түрээсийн орлогын төлөвлөгөө 101 хувиар, цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зэрэг харилцагч байгууллагуудын хэрэглэсэн хэрэглээний төлбөрийн үндсэн бус үйл ажиллагааны орлого 96 хувиар тус тус биелсэн.

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцдаг санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад тушааж, тайлангийн хугацаанд улсын төсөвт 91,776.9 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, 173,308.4 мянган төгрөг (үүнээс 115,334.1 нь компаниас, 57,974.3 нь даатгуулагчаас)-ийн нийгмийн даатгалын шимтгэл, 106,708.3 мянган төгрөг (ажиллагсдаас суутгасан 90,930.9, ажил үүрэг гүйцэтгэгчээс суутгасан 2,925.6, ногдол ашгаас суутгасан 12,851.8 мянган төгрөг)-ийн хувь хүний орлогын албан татвар, 11,324.6 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, газрын болон авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар, 209,759.9 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлж, улсын төсөвт төлөх төлбөрийн 95.4 хувийг тайлангийн хугацаанд барагдуулсан байна.

Анкор төв үйл ажиллагааны чиглэлийн дагуу хурал, семинар, уулзалт 34, хүлээн авалт 5, үзэсгэлэн худалдаа 2, нийт 41 удаагийн, 307 цагийн арга хэмжээ, үйлчилгээ зохион байгуулж, (НӨАТ-гүй дүнгээр) 34,208.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан.

Компанийн өмч хөрөнгөнд жилийн эцсийн тооллого явуулж, 13,306,453.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 12,601.2 мянган төгрөгийн бараа материал, 26,897.6 мянган төгрөгийн хангамжийн материал тоолсноос, хуучирч ашиглагдахгүй болсон, ашиглалтад олгогдсон, өөрийн өртөггүй болсон зэрэг 14,790.9 мянган төгрөгийн хөрөнгө актлав.

Компани 2018 онд 3,496,998.5 мянган төгрөгийн орлоготой, 2,603,006.8 мянган төгрөгийн зарлагатай, 799,088.7 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого 3,391.4

мянган төгрөг буюу 0.1 хувиар өсч, зардал 4,714.6 мянган төгрөг буюу 0.2 хувиар буурч, хуримтлагдсан ашиг 4,501,141.7 мянган төгрөг болж 17.5 хувиар өссөн байна.

### **Ажлын байр, ажиллах нөхцөлийг хангах чиглэлээр**

Ажлын нөхцөлийг хангах зорилгоор 12,963.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (компьютер, принтер, хөргөгч, ус соруулах насос зэрэг), 3,025.0 мянган төгрөгийн хангамжийн материал (халаах төхөөрөмж, соронзон карт) худалдан авч бэлтгэсэн. Анкор төвд 5,195.0 мянган төгрөгийн хангамжийн материал зарцуулж, 3,365.7 мянган төгрөгийн хангамжийн материал акталж, данс бүртгэлээс хассан.

Үндсэн хөрөнгө худалдан авахаар төлөвлөсөн ажлаас:

- Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийг сайжруулах төслийн хүрээнд манай компанийн МА-III барилга дахь дулааны үзельд 2005 онд халаалтын цогц төхөөрөмж суурилуулсан. Уг төхөөрөмжийг үлдэх өртгөөр нь 2018 онд авахаар төлөвлөсөн боловч Улаанбаатар дулааны шугам сүлжээ ХК ялтсан бойлуурын гэмтэлтэй тоног төхөөрөмжүүдийг засварлаж, бүрэн ажилд оруулаагүй тул төлөвлөгөөнд тусгагдсан 33,000.0 мянган төгрөгийн дулааны ялтсан бойлерын худалдан авалт хийгдээгүй.
- Анкор төвийг Мондактс ХХК-д түрээсийн төлбөртэй эзэмшүүлэх болсон тул төлөвлөгдсөн 22,560.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг худалдаж аваагүй.

Компанийн оффис, Анкор төв, засварчдын өрөөнүүдийн утасгүй /wireless/ сүлжээ, Wireless Access point төхөөрөмж, Unifi controller серверийг шинээр суурилуулах 1,805.8 мянган төгрөгийн ажлыг Супрэйм солюшн ХХК-тай гэрээ байгуулан хийлгэснээр утасгүй сүлжээний төхөөрөмжүүд 300 Mbps хүртэл хурдаар 120 метр хүртэлх хэмжээнд мэдээлэл дамжуулдаг болж, нууцлал, сүлжээний хамгаалалт сайжирсан.

Мөн компанитай байгуулсан гэрээний дагуу оффисын сервер, принтер, компьютеруудад өдөр тутмын тохируулга, үйлчилгээг 4,800.0, нийт 14 компьютер болон сүлжээний серверт Касперски антивирусын программыг 859.0, оффисын 12 компьютерийн санах ойг 1,040.0, бусад (уртасгагч, хард диск, кабель далдлагч худалдан авах зэрэг) ажлуудыг 2,015.4 мянган төгрөгийн зардлаар хийлгэсэн.

Компанийн нутаг дэвсгэрийн гаднах орчны хяналтын зориулалтаар 4, Гурвалжингийн аж ахуйн хашаа, агуулахад 4 камер, холбогдох төхөөрөмжүүдийг 3,700.0 мянган төгрөгөөр тавьж суурилуулах ажлыг өөрсдийн хүчээр хийж ажиллагаанд оруулсан.

Компанийн бөбсайтыг шинэчлэх, хөгжүүлэх 1,500.0 мянган төгрөгийн ажлыг Супрэйм солюшн ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хийлгэсэн.

Компанийн төв оффисын нутаг дэвсгэр, гурвалжин дахь аж ахуйн хашаа, агуулахад шинээр 8 камер суурилуулж, компанийн нутаг дэвсгэр, оффис, Анкор төв,

автомашины гарааш, дулааны үзель, цахилгааны ХТП 0477 дэд өртөө зэрэг гадна болон дотор талд хяналт тавих 24 цагаар ажилладаг нийт 32 камерийн тохиргоо үйлчилгээг тогтмол хийж хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

ЗАХИРГААНЫ АЛБАНЬ  
ДАРГА



Ч. ДОРЖГОТОВ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

П. ЭНХНАСАН